

АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж заасны дагуу аудит хийх чиг үүргээ гэрээгээр гүйцэтгүүлэх тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахь мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Аудитын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний болон энэхүү зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулна. Аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабарт хугацаатай нийцсэн байх.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасан нөхцөл байдал үүсгээгүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 болон 14.1.7-д заасан нөхцөл байдал үүсгээгүй талаарх шүүхийн тодорхойлолт
- Санхүүгийн тайланд аудит хийж байсан 2-оос доошгүй жилийн туршлагын талаарх мэдээлэл
- Аудитын компанийн удирдлага болон аудиторчуудын дэлгэрэнгүй анкет /аудиторын ур чадвар болон ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээллийг заавал тусгана/ болон иргэний үнэмлэхийн хуулбар, дипломын хуулбар, мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний хуулбар, аудит болон баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийн хуулбар /хуулбарыг нотариатаар баталгаажуулах/
- Аудитын хуулийн этгээд нь гэрээт ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай аудитортой байна.
- Үйлчлүүлэгч байгууллагын баримт материалыг хүлээж авах, хадгалах шаардлага хангасан ажлын байр, тоног төхөөрөмжийн жагсаалт /шаардлагатай зарим бичиг баримтын хуулбар/
- Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь ёс зүйн болон мэргэжлийн алдаа зөрчил гаргаж байсан эсэх талаарх Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтын тодорхойлолт
- Сангийн Яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт тайлан ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 12-р сарын 08-ний өдрийн 17 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 12-р сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү.

Төв аймгийн Төрийн захиргааны 2-р байрны 1 давхар 107 тоот өрөө
Төв аймаг дахь Төрийн аудитын газар

Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо
Утас:70273204, 99019602, 99018619